



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/561

Улаанбаатар хот

「Хан-Уул дүүргийн 223 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,500,000.00 (найман сая таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Хан-Уул дүүргийн 324 дүгээр цэцэрлэгт хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 223 дугаар цэцэрлэг (Д.Туяа)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 324 дүгээр цэцэрлэг (Г.Туяа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 10 -ны өдрийн А/56/ дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 223 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт- анд орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ / төгрөгөөр /		Хуримтлагдсан элэгдэл /2024.09 сар/	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
						нэгж үнэ	нийт үнэ			
Машин тоног төхөөрөмж										
1	1-р хоолны тогоо	2024	сайн	ш	1	3,500,000.00	3,500,000.00	291,666.66	3,208,333.34	Хан-Уул дүүргийн 324 дүгээр цэцэрлэг
2	2-р хоолны тогоо	2024	сайн	ш	1	5,000,000.00	5,000,000.00	416,666.64	4,583,333.36	
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн							8,500,000.00	708,333.30	7,791,666.70	